



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/587

Мөрөн сум

Хадгалах хугацаа дуусаж,
шаардлага хангахгүй болсон өвс
тэжээлийг актлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.7, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Онцгой комиссын Хурлын 2024 оны 09 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал хамгаалах сангаас 2021 онд нэр бүхий сумдад тараагдсан өвсний чанар байдлаас хамаарч ашиглагдаагүй, төлбөр нь хийгдээгүйн улмаас олон он дамжин найдваргүй авлага болсон тул үүссэн 57,912.074 (тавин долоон сая есөн зуун арван хоёр мянга далан дөрөв) төгрөгийг санхүүгийн тайлан бүртгэлээс хасахыг, мөн мал хамгаалах сангийн хөрөнгөөр 2023 онд бэлтгэсэн 17,385,134 (арван долоон сая гурван зуун наян таван мянга нэг зуун гучин дөрөв) төгрөгийн үнэ бүхий өвс, тэжээл нь хадгалалтын хугацаа дуусаж ашиглах боломжгүй болсон тул тус тус акталж тайлан бүртгэлээс хасахыг зөвшөөрсүгэй.

2. Шийдвэрийг байгууллагын Өмч хамгаалах комиссын хурлаар хэлэлцэн эцэслэн шийдвэрлэж зохих хууль журамд нийцүүлэн санхүүгийн тайлан тооцоонд тусгаж тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Э.Улам-Өсөх), Мал хамгаалах сангийн нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-т даалгасугай.

3. Хугацаа дуусаж, шаардлага хангахгүй болсон өвс, тэжээлийг зохих заавар журмын дагуу устгах арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллахыг Мал хамгаалах сангийн нярав (С.Анхбаяр)-т даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ